- “Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт 2022 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Цусны донорын тухай, Тамхины тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилласан байна;

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр “Журам батлах тухай” тушаал;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 06 дугаар тогтоол;
- “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн А/407 дугаар тушаал;
- ЭМСайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалаар “Төрийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй үйлчилгээний жагсаалтыг баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 09, 14 дүгээр тогтоол;
- Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 49, А/118 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг баталсан;
- ЭМС-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний журам”, хоёрдугаар хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус баталсан;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2-т “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 05 болон 06 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 2-т “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 7, 8, 9, 10 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал;

Байгууллагын дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн А/13 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2 дугаар хавсралтаар “Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын журам”-ыг баталсан байна. “Дотоод хяналт шалгалтын зорилго нь Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ЭМС-ын тушаалд заавал мөрдөх стандарт, клиникийн удирдамж, байгууллагын дотоод журам, байгууллагын удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийн хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хууль, дүрэм

журмыг мөрдүүлэхэд дотоод хяналтын зорилго оршино” гэж үйл ажиллагааг нь тодорхойлсон.

Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хийх дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92,745.5 мянган төгрөгөөр буюу 12,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	999.8	69,063.6	68,063.8
Авлага	62,288.3	10,421.5	(51,866.8)
Урьдчилгаа	-	7,458.8	7,458.8
Бараа материал	96,884.7	108,461.9	11,577.1
Үндсэн хөрөнгө	587,005.1	644,517.6	57,512.5
Нийт хөрөнгө	747,177.9	839,923.4	92,745.5
Өр төлбөр	9,817.0	10.0	(9,807.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	737,360.9	839,913.4	102,552.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	747,177.9	839,923.4	92,745.5

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, авлага, өр төлбөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 68,063.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 51,866.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.
3. Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 7,458.8 мянган төгрөгөөр өссөн нь Петростар компанийн шатахууны IC картад 7,458.8 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, шатах тослох материалын үлдэгдлээр бүртгэсэн нь нөлөөлсөн байна.
4. Бараа материал өмнөх оноос 11,577.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Эрүүл мэндийн газар 24,222.8 мянган төгрөгийн эм вакцин, хэрэгсэл үнэ төлбөргүйгээр, төсвийн хөрөнгөөр 82,287.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 94,938.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 57,512.5 мянган төгрөгөөр нэмэгдэхэд ЭМГазар, Эрүүл мэндийн яамнаас 59,615.3 мянган төгрөгийн авто машин болон эмнэлгийн тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй орлогодож, төсвийн хөрөнгөөр 31,434.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь нөлөөлсөн байна.
6. Өглөг 9,807.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.
7. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 102,552.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үр дүн өссөн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 478,488.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 404,664.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 38,227.0 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 61,206.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 491,909.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 32,199.3 мянган, нийт 524,524.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 456,460.8 мянган төгрөг буюу 90,6 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 17,366.8 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,359.5 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,814.8 мянган, хангамж, бараа материалын зардал 4,358.8 мянган, нормативт зардлыг 9,582.6 мянган, эд хогшил худалдан авах зардал 5,520.6 мянган, томилолт, зочны зардал 493.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 3,140.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 5 хөтөлбөрийн 47,636.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80302-Нэг иргэнд ноогдох норматив	246,507.9	221,160.6	25,347.3	89.7
2	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	158,156.3	144,403.0	13,753.3	91.3
3	83603-Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	61,206.4	58,697.9	2,508.5	95.9
Дүн		465,870.6	424,261.6	41,609.0	91.1
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	37,179.0	31,304.2	5,874,807.8	-
2	80112-Нийтлэг үйлчилгээ	1,048.0	895.1	152,930.0	85.4
Дүн		38,227.0	32,199.3	6,027,737.8	84.2
Нийт дүн		504,097.6	456,460.8	6,069,346.8	90.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төв нь Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 1/318 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн 2-т “Гүйцэтгэлээр санхүүжилт авч буй төсвийн байгууллагууд нэмэлт дансыг ашиглахгүй, хуучин ашиглаж байсан үндсэн дансаар орон нутгийн санхүүжилт авч байгаа тул тус тус дансанд байгаа урьд оны үлдэгдлийг “урьд оны үлдэгдлээс санхүүжих-3000006” ангиллаар үндсэн дансанд шилжүүлж “Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/” зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 120010” ангилалд орлого хуваарилан зарцуулах” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар ажил, гүйлгээ гараагүй тул нэмэлт санхүүжилтийн тайлан бэлтгэгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.0 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлын 504,097.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,024.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,517.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 47,782.8 мянган төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 156 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 132,177.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 242,749.0 мянган төгрөгөөр буюу 110,572.0 мянган төгрөгөөр илүү, байршуулж, 3 удаагийн 77,272.4 мянган төгрөгийн орлого, 1 удаагийн 5,874.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, холбогдох заавар аргачлалаар хангаж ажиллах зөвлөмж өгөв.

2. Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь байгууллагын дүрэм, хөтлөгдөж буй албан бичиг баримтад Сумын эрүүл мэндийн төв гэсэн нэрээр бүртгэлтэй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "Сум, тосгоны эрүүл мэндийн төв", Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 5 байгууллагын худалдан авалтыг 45,053.4 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм,

журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мөнгөнморьт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 266,261.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр бүрэн хэрэгжүүлсэн гэж хүргүүлсэн боловч гүйцэтгэлийн үе шатанд шалгахад 25.9 хувийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	262,650.7	2	68,931.5	26.2
Албан шаардлага	1	3,575.7	-	-	-
Төлбөрийн акт	1	34.7	1	34.7	100.0
Нийт дүн	4	266,261.1	2	68,931.5	25.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл тайлагналыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,230.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн зардлын дүн ерөнхий журналын цалингийн зардлын дүнгээс 1,999.6 мянган төгрөгөөр, цалингийн гарт олгох дүн нь ерөнхий журналын гарт олгосон цалингийн дүнгээс 7,805.3 мянган төгрөгөөр тус тус дутуу, нийт 9,805.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэнийг;
- Хувь хүний орлогын албан татварын тайланг цахим тайланд илгээхдээ цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 30 хүний цалин хөлсийг 8,425.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг тус тус Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 8,024.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 8,024.1 мянган төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 19 ажилтанд томилолтын зардлыг олгохдоо 78.0 мянган төгрөгийн хоолны олговрыг давхардуулан олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Урамшуулалт цалингийн дүнгээс 487.3 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3. Тайлант оны эцэст урьдчилж төлсөн тооцоо болох Петростар компанийн шатахууны IC картад 7,458.8 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, шатах тослох материалын үлдэгдлээр бүртгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. **Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн зардлын дүн ерөнхий журналын цалингийн зардлын дүнгээс 1,999.6 мянган төгрөгөөр, цалингийн гарт олгох дүн нь ерөнхий журналын гарт олгосон цалингийн дүнгээс 7,805.3 мянган төгрөгөөр тус тус дутуу, нийт 9,805.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн байна.	1	9,805.0	-	-	1	9,805.00	1	9,805.00	-	-	-	-
Хувь хүний орлогын албан татварын тайланг цахим тайланд илгээхдээ цалин цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 30 хүний цалин хөлсний орлогыг 8,425.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	8,425.0	-	-	1	8,425.00	1	8,425.00	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланд эмчлүүлэгсдийн тоог тайлагнаагүй байна.	1	-	1	-			1		-	-	-	-
Дүн	3	18,230.00	1	-	2	18,230.00	3	18,230.00	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэр бүхий 19 ажилтанд томилолтын зардлыг олгохдоо 78.0 мянган төгрөгийн хоолны олговрыг давхардуулан олгосон байна.	1	78.0	1	78.0	-	-	-	-	-	-	-	-
Урамшуулалт цалингийн дүнгээс 487.3 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.	1	487.3	1	487.3	-	-	-	-	-	-	-	-
Тайлант оны эцэст Петростар компанийн шатахууны IC картад 7,458.8 мянган урьдчилан шилжүүлж Шатах тослох материалын үлдэгдлээр бүртгэж тайлагнасан байна.	1	7,458.8	1	7,458.8	-	-	-	-	-	-	-	-
Дүн	3	8,024.1	3	8,024.1	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 156 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 132,177.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 242,749.0 мянган төгрөгөөр буюу 110,572.0 мянган төгрөгөөр илүү, байршуулж, 3 удаагийн 77,272.4 мянган төгрөгийн орлого, 1 удаагийн 5,874.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.	1	193,719.2	-	-	1	193,719.20	-	-
Дүн	1	193,719.2	-	-	1	193,719.2	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн худалдан авалтын төлбөрийн и баримтын дүнгээс 5 байгууллагад 45,053.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	45,053.4	-	-	-	-	1	45,053.4
Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	3	45,053.4	-	-	-	-	3	45,053.4
Нийт дүн	4	238,772.6	-	-	1	193,719.2	3	45,053.4